

ТӨГСӨГЧДӨӨС ИЛГЭЭСЭН ЗАХИДЛУУД

ГАДААДЫН ИХ ДЭЭД
СУРГУУЛИУДАД ХЭРХЭН
СУРАЛЦАХ ТАЛААР



ШИНЭ ЭРИН СУРГУУЛИЙН
ТӨГСӨГЧИЙН
ХОЛБОО

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

 ТАЙВАНЬ	4
 СИНГАПУР	5
 ЭНЭТХЭГ	6
 СОЛОНГОС	8
 СОЛОНГОС	9
 ИХ БРИТАНИ	10
 УНГАР	11
 УНГАР	12
 ЧЕХ	14
 КАНАД	15
 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	18
 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	20
 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	21
 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	22
 ХЯТАД	24
GAR YEAR БУЮУ ЖИЛИЙН ЧӨЛӨӨ АВАХ	25

ӨМНӨХ ҮГ

Гадаадын их сургуулиудад амжилттай суралцах ялангуяа хамгийн шилдэг дээд боловсролыг олж авах талаар мэдээлэл хомс байх олонтаа. Ихэнх тохиолдолд сурагчид дөнгөж 11 болон 12 дугаар ангид орох үедээ л бага хэмжээний мэдээлэлтэй болж эхэлдэг нь харамсалтай. Мэдэхгүй, мэдээлэлгүйгээсээ болж асар их хэмжээний цаг алдах нь маш том сул тал юм. Учир нь гадаадын орнуудад сурагчид 8, 9 дүгээр ангиасаа эхлэн их сургуульд явуулах өргөдлийнхөө талаар судалж эхэлдэг. Энэ нь тэдгээр сурагчдад бусдаас түрүүлж алхах боломж олгодог бөгөөд төгсөх ангидаа орох үед бүх зүйл нь бэлэн болсон байдаг юм. Үүгээр зогсохгүй аль улсын их сургуульд явбал ямар орчинд очих, ямар үүрэг хариуцлага хүлээж байдаг талаар төсөөлөл муу байдаг билээ. Очсон хойноо юун дээр анхаарах ёстой, ямар ямар зүйлсийг мэдэх ёстойг зарим тохиолдолд өөрийн биеэр очихоос өөрөөр мэдэх аргагүй байдаг.

Тэгвэл энэхүү ном нь эдгээр бэрхшээлүүдийг яаж даван туулах талаар танд бага ч гэсэн мэдээлэл өгөх юм. Учир нь энэхүү ном нь төгсөгчдийн зүгээс доод ангийнхаа дүү нарт зориулан зөвлөгөө болгож бичсэн захидлуудын эмхэтгэл билээ. Аль хэдийн Шинэ Эрин сургуулиа төгсөн алс холын орнуудад дээд боловсрол эзэмшиж буй төгсөгчид өөрсдийн туршлагаас хуваалцаж байгаа юм. Явахаасаа өмнө, ямар ямар зүйлсийг бэлдэх, өгөх шалгалтууд, давах шалгууруудыг нэгд нэгэнгүй тайлбарласан бөгөөд өөрсдийн бэлдэж байсан аргачлал зэргийг тусгасан юм. Түүнчлэн тус улсадаа сурах үед мэдэх ёстой ерөнхий мэдээлэл, зааварчилгаа, бас сурах орчин зэргийг дурдсан билээ. Хамгийн гол нь эдгээр зөвлөгөөнүүд өөрсдийнх нь туршлага дээр үндэслэсэн бөгөөд өөрсдийн төгссөн сургуулийнхаа одоогийн сурагчдад туслах гэсэн чин сэтгэлийн үүднээс бид бэлдэж оруулав.



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Миний бие Долоонжин овогтой Пүрэвтуяа Шинэ Эрин сургуулийн анхны төгсөгчдийн нэг билээ. Одоогийн байдлаар Тайвань улсын National Dong Hwa University-д 50 хувийн тэтгэлэгтэй Сэтгэл судлалын чиглэлээр 3 дахь жилдээ суралцаж байна. Манай сургууль гадаад оюутнуудыг элсүүлэн авахдаа TOEFL IBT шалгалтын 61 оноог шаарддагаас гадна тус сурагчийн 10 жилийн дүнгүүд дээр тулгуурладаг. Тус сурагчийн нийгмийн идэвх Тайвань улсын сургуулиудад элсэн ороход томоохон туслалцаа үзүүлдэг. Ялангуяа сайн дурын ажил. Учир нь Тайвань улсын иргэд нь бүгд их найрсаг, тусархаг, идэвх чармайлттай хүмүүс байдаг.

Амьдрах өртгийн талаар дэлгэрэнгүй:

1. Сургалтын төлбөр (1 Сэместэр)- 60000 NTD= 4350000 MNT
2. Дотуур байр (1 Сэместэр)- 12000 NTD= 852000 MNT (Дотуур байр нь нийтийн гал тогоотой учир хүссэн хоолоо хийж идэхэд хэцүү. Гадуур байр хөлсөлж амьдрах сонголт байж болно. Байрны мөнгө дотуур байрныхтай адилхан. Гэхдээ тог болон интернэтийн мөнгө сар болгон нэмж төлнө. Хүссэн хоолоо хийгээд идэж болно.)
3. Эрүүл мэндийн даатгал (1 Сэместэр)- 3000 NTD= 213000 MNT (Эрүүл мэндийн даатгалтай бол ямар ч эмнэлэгт маш хямд үзүүлнэ.)

Анхаарах зүйлс:

1. Зузаан хувцас авчрах- ихэнх хүмүүс Тайванийг халуун орон гэж боддог ч гэсэн өвөлдөө борооны улирал их жиндүү хүйтэн байдаг. Учир нь Тайвань маань өөрөө арлын орон. Далайтай их ойрхон учраас ийм уур амьсгалтай.
2. 20 нас хүрээгүй бол утасны дугаар авахад хэцүү байдгийг анхаарна уу. Онгоцны буудлаас шууд авч болно
3. Гадаадад сурах гэж байгаа учир гадаад паспортын хугацааг сайн сунгуулж ирэх

Тайвань улс нь амьдарч суралцах таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн. "Азийн бар" гэгдэх өндөр хөгжилтэй 4 орны нэг юм. Эмх цэгцтэй, дэг журмыг сайн сахьдаг энэ улсын маань хамгийн том давуу тал нь гагцхүү аюулгүй байдал гэж би хувьдаа бодож байна. Гадаадад суралцах нь амархан зүйл биш учраас миний хувьд аюулгүй, тайван байх нь нэн чухал.

ХҮНДЭТГЭСЭН:

Д. ПҮРЭВТУЯА (2013 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Мөнхтогтохын Тэмүлүн миний бие Шинэ Эрин сургуулийг 2016 онд дүүргэж амжилттай суралцан төгссөн билээ. Амьдралын их далайд гараад гэрээсээ ганцаараа өөр улсруу явсан туршлагаасаа сонирхуулья.

Сингапур улс нь бусад орноос давуу талтай нь илүү богино хугацаанд дээд боловсрол олгох бүрэн боломжтой байдаг. Үүнд шалгуур нь 10 жилийн дүн, өөрийн хувийн мэдээлэл, англи хэлний шалгалт, мөн амжилт үзүүлэлтийн оноо нь элсэхэд дөхөм болдог. Миний хувьд элсэн ороход илүү дөхөм болгож нээлттэй болгосон зүйл маань Шинэ Эрин сургуулийн боловсролын тогтолцоо нь тус коллэжийн жишигт нийцэн хүлээн авсан. Визанд хамрагдах зайлшгүй шаардлагтай. Хэрэв хичээлийн ирц 90% доош хувь байвал визаны хугацааг сунгадаггүй гэх зэрэг хатуу дүрэмтэй.

Тус улсад суралцах сонирхолтой, явахаар төлөвлөж байгаа бол одооноос төгсөлтийн дүн болох, чиний бүрэн дунд боловсролыг хэрхэн эзэмшсэн нь томоохон нөлөө болдог. Сургуулийн элсэлт нь ихэвчлэн 5-7 сарын хооронд авдаг.

Коллежийн амьдралын хувьд Сингапур нь оюутнуудад илүү их боломжийг олгож олон олон анги танхимыг бэлдэж өгсөн байдаг. Үүнд хичээлээ тараад номын санд хичээлээ хийх, ангиараа чөлөөт цагаараа кино үзэх, тоглоом тоглох, фитнэссээр хичээллэх, усан санд сэлэх, гадаа талбай д нарлах гэх мэт маш олон сонирхолтой зүйлсээр хангаж өгсөн байдаг нь миний хувьд маш гайхалтай санагдсан. Мөн дурдахад Сингапур улс нь дэлхийн хамгийн аюулгүй хот доо багтдаг учраас энэ

газарт амьдрах, шөнөөр алхах гэх зэргээс огтхон ч эмээхгүй байж болно. Сургууль ч тэр оюутны дотуур байр нь ч тэр 24/7 хамгаалалттай. Маш цэвэрхэн орчин, найрсаг хамт олонтой учраас суралцахад тохиромжтой юм. Мөн энэ улс нь бүгд англи хэлээр ярьдаг учраас хэлийг төгс эзэмшихэд бидний хувьд нээлттэй.

Үнэ өртгийн хувьд бусад орноос хамаагүй өндөр. Нэг сургуулийн төлбөр ихэвчлэн 5 мянган доллараас - 22 мянган доллар байдаг, мөн амьдрах өртөг нь манай улсыг бодвол 2 дахин илүү өндөр. Байрны түрээс сард монгол мөнгөөр нэг сая орчим мөнгө байдаг тул санхүүгийн тал дээр нарийвчлан анхаарах нь зүйтэй.

Тэтгэлгийн хувьд сургууль болгон өөр өөр шаардлагатай байдаг учраас сонирхож буй сургуулиасаа мэдээллээ аваарай. Сургалтын сайн тал нь хэнд ч юу ч сурахад нээлттэй, багш нар нь туслахад бэлэн. Сургалтын түвшин, хүргэж буй явц хамгийн өндөр. Харин нэг муу тал нь нэг улсын хүмүүстэйгээ нэг доор байхад суралцахад ихээхэн саад болж, үндсэн үүргээсээ халих эрсдэлтэйг ирээд хамгийн томоор харлаа. Анх ирэхэд монгол оюутнууд байсан ч ихэвчлэн хичээл, эрдэм номыг гол зорилгоо болгох бус зугаа цэнгэл, хөгжилдөөнийг эрхэмлэсэн нь төлхүү харагдаж байсан.

Хэн бүхэнд нээлттэйн адил хэн бүхэнд энд хүрэлцэн ирж суралцах боломжтой шүү.

ХҮНДЭТГЭСЭН,

М. ТЭМҮЛҮН (2016 ОНЫ ТӨГСӨГЧ)



Би Шинэ Эрингийн анхны төгсөгчдийн нэг Т.Билгүүн байна. Одоогоор би Энэтхэг улсын Банглор хотод Bangalore University-ийн сургалтын жишгээр хичээллэдэг Acharya Institute of higher education коллеждод Bachelors of Computer Applications курс сурч байгаа.

Мэдээж Шинэ Эринд байхдаа IGCSE болон AS level шалгалтууд өгсөн. IGCSE-н үнэлэмж өндөр учраас сайн дүн авбал их хэрэг болно. Тиймээс боломжтой байгаа дээрээ IGCSE-дээ сайн бэлдээд өндөр оноо авах нь чухал. Цаашаа өөрийнхөө хүссэн мэргэжлийн дагуу их сургуулийн шаардлагуудыг шалгаж AS/A түвшний шалгалтыг сонирхож болно. Миний хувьд бол би SAT эсвэл TOEFL гэх мэтийн шалгалтууд өгөөгүй. IELTS-г сонирхож байгаад өгч 7.0 оноо авсан. IELTS-д эхлээд бичгийн шалгалт, дараа нь ярианы шалгалт өгнө.

Харин Энэтхэгийн засгийн газрын тэтгэлэгт оролцохдоо би бас нэгэн бичгийн шалгалт өгсөн. Энэ нь IELTS-аас харьцангуй хялбар байсан. Тэгж дараагийн шат буюу ярилцлагадаа тунаж үлдээд, Энэтхэгийн элчин сайдын яам дээр ярилцлагад орсон. Бүх зүйлс асуудалгүй болж өнгөрсөн ба Энэтхэгт суралцах эрхийг авсан 4 хүүхдийн нэг нь би болсон юм. Мэдээж бичгийн шалгалтад голчлох зүйлс нь "writing" болон "reading". Writing хийж байх үед юу бичих гэж байгаагаас шалтгаалан формат буюу загвараа бэлтгэх хэрэгтэй. Topic sentences буюу гол санааг агуулсан өгүүлбэрүүдээр параграфуудыг эхлүүлж, нэг параграф дотор хэд хэдэн санааг дэвшүүлэх ёстой.

Анхаарах зүйлс нь гэвэл юу бичихээ мэдэхгүй бодож цаг алдах, мөн гол санаанаасаа хазайж хамааралгүй юм бичих нь осолтой. Үгийн тоог олшруулах гэж юм бичих хэрэг гардаг ч, санаанаасаа хадуурч болохгүй. "Reading" бол их энгийн

зарчимтай. Өгөгдсөн текст дотроос асуултанд хариулах мэдээллүүдийг олох. Цаг хангалттай байгаа бол текстээ нэг удаа бүрэн бөгөөд хурдан унших хэрэгтэй. Энэ аргыг "skim reading" гэдэг. Мөн яваандаа асуултад таарах хариулт хаана байгааг гадарлаж олохдоо илүү сайжирна. Энэ төрлийн мэдээлэл тэр хэсэгт л байгаа гэж ерөнхийд нь текстээ хувааж ажиглах хэрэгтэй.

Би хувьдаа юм цээжлэх л биш бол аливаа зүйлийг сурахад дөт зам байдаггүй гэж боддог. Нэг шалгалтын хуудсыг хийж дуусгасныхаа дараа өөрийгөө жижиг бөгөөд дуртай зүйлсээрээ урамшуулаад толгойгоо сэргээгээд буцаад хичээлээ хийнэ. Хичээл сурлагад ганц л дайсан байдаг. Тэр бол залхуурал буюу тухайн хүний ухамсар. Өөр ямар ч шалтаг байхгүй.

Миний ээж англи хэлний багш учир бас надад олон зүйлс зааж өгч намайг бэлтгэдэг байсан. Ярианы чадварыг бие дааж өөрөө л сурсан. Гэвч яг бусад хүмүүстэй ярьдаг уу гэхээр үгүй. Би багаасаа компьютерыг сонирхож оролддог байсан. Би гадаад форумуудаар их зочилж, тэнд хүмүүстэй харилцан бичилцдэг байсан. "Гэхдээ бичих нь ярихад ямар үр нөлөөтэй юм?" гэж асуумаар байгаа биз? Миний бодлоор энэ арга нь яг ярианы дуудлагыг сайжруулахгүй ч, англиар сэтгэж боддог болгодог. Нэг л мэдэхэд би дотроо Монголоор бодох нь маш багасч, ихэвчлэн англиар боддог болсон. Боддог гэдэг нь толгой дотроо өөртэйгөө ярих гэсэн үг юм. Өөртэйгөө ярих гэхээр инээдтэй сонсогдож магадгүй, гэхдээ тэгж хэвшил болгох нь давуу тал ихтэй байх.

Энэтхэг бол маш сонирхолтой орон. Энд юу л бол юу байна. Банглорын цаг агаар нь сүртэй өөрчлөгддөггүй, улирал өөрчлөгдөж байна гэж мэдэгддэггүй. Банглор хот халуун биш, харин ч борооны

улирлын үеэр маш сэрүүхэн болдог.

Манай коллежд кредитээ өөрийнхөө хичээлүүдийг сонгохгүй. Цаанаасаа гаргасан цагийн хуваарийн дагуу тогтмол хичээлтэй байдаг. Хүмүүс нь маш яриасаг. Яриад л байна яриад л байна. Мөн олон хүнтэй учир дуу чимээ их, хөл хөдөлгөөн их. Тансаг газруудаар ч, захын тосгоноор ч би орж үзсэн. Ялгаагүй сонирхолтой байсан. Тосгонд байхад өглөө сэрээд жимсний тариалан дундуур алхах маш сайхан. Гадаадад сурч байгаа оюутан сурагчдад хамгаас чухал нөөц баялаг бол цаг хугацаа. Аль болох завгүй идэвхитэй байж, зөв зүйлд цагаа зарцуулах хэрэгтэй.

Юуны өмнө би засгийн газрын тэтгэлэгтэй тул сурлагын төлбөр төлөхгүй. Нислэгийн мөнгийг би өөрөөсөө гаргана. Сар бүр стипенд мөнгө авах боловч яг цаашид хадгалахаар мөнгөний эх үүсвэр бол биш. Гэвч надад бол ямар ч мөнгөний асуудал гараагүй. Тэтгэлгийн дүрэм дээр оюутнууд ажил хийж болохгүй гэдэг ч, би шууд бус аргаар мөнгө олдог. Нэг нь гэвэл би АниКод хэмээх орчуулгын вэбсайтыг эзэмшдэг бөгөөд түүн дээр зар сурталчилгаа тавьж, түүнтэй холбосон Энэтхэгийн банкны дансанд маань орлого орж ирдэг. Мөн яг одоо би freshers буюу доод ангийн ганц хоёр оюутнуудад хичээлийг нь зааж өгөн гэрийн багш маягийн зүйл хийж байгаа тул надад гэрээсээ мөнгө авах шаардлага гарч байгаагүй. Энэ тэтгэлэг зарлагдахад би шалгалтад нь оролцсон. Шаардлага нь мэдээж голч оноо 3-аас өндөр ч билүү, нэг тийм байсан. 1-р курсээ төгсөөд Энэтхэг явж баклавраар дахин сурч эхэлсэн гэсэн үг. Шалгаруулалтын хоёр шалгалтад нь би тэнцэж Энэтхэгт суралцах эрх авсан. Тэтгэлэгтэй суралцах гэдэг бол их хариуцлага шаардсан зүйл. Юуны өмнө сайн сурагч байх ёстой. Тэр нь яг илүү сайн сургуульд өндөр түвшний мэдлэг хуримтлуулах хүсэлтэй байх гэсэн үг. Ээж аав нь хүүхдээ дамжаанд явуулаад л байдаг, харин үр бүтээлгүй яваад байвал нэмэргүй. Мөн дамжаанд явсан ч, гол бэлтгэл нь дамжааны гадуурх өөрийн хичээл зүтгэлээс шалтгаалдаг.

За сурах хүсэлтэй, Harvard MIT Cambridge-д орох мөрөөдөлтэй юм байж. Гэвч яг тэнд суралцахын төлөө яг одоо арга хэмжээ авахгүй, "MIT-д сураад Google-д орох юмсан" гэж л урам өгөх видео үзэх болгондоо бодоод байвал нэмэргүй. Тиймэрхүү том сургуулиудад орох нь боломжгүй юм биш, гэхдээ бодит байдлыг сайн харах хэрэгтэй. "Harvard-д 100%-ийн тэтгэлэгтэй, голч оноо 2.5-аас өндөр байх" гэсэн зарлал хаанаас ч олдохгүй. Одоо мэдлэг, чадвараа яаж сайруулах вэ гэдгийг тодорхойлж тэрийгээ тууштай биелүүлэх хэрэгтэй. Тэгж явж байх зуур боломжийн оронд тэтгэлэгтэй сурах боломч гарч ирэх болно. Харин нээлтэй боломж олдсон үед манай Шинэ Эрин сургуулийн сайн сурагчид алдана гэж би бодохгүй байна. Гол нь үргэлж өөрийгөө бэлтгэж, мөн тэр боломж буюу opportunity-г сайн хайх хэрэгтэй.

Энэтхэгт суралцвал миний бодлоор илүү нээлттэй, чөлөөт сэтгэлгээтэй болно. Нээлттэй гэдэг нь зөвхөн ярианы тухай биш юм. Энэтхэгт маш олон төрлийн шашин, соёл заншил байдаг тул тэр бүгдийг нь үзэж, зан үйлд нь хамт оролцож амьдралын хэв маягаа өөрчилдөг. Мөн Энэтхэгт зардал, өртөг маш бага. Жишээ нь би 3000 төгрөгтэй дүйцэх мөнгөөр 2 том талх, 4 өндөг, 1кг төмс, 2 гадил авч болно. Байр түрээсэлж амьдарсан ч Монголоос харьцангуй хямд. Албан байгууллагуудын ажлын явц их удаан юм шиг санагддаг. Бас хүнд сурталтай хүмүүс олон. Байгууллагын дээд тушаалтнууд тэгээд л байр сууриараа далайлгах явдал хааяа гарна. Гэхдээ хаана ч ялгаагүй ийм байдаг байх. Аан бас цаг агаарын хувьд их дажгүй. Банглор хот сэрүүхэнд тооцогддог. Харин би Дэли-д байхад шатах гэж байдаг байсан. Тэр үед өдөрт 2 удаа хүйтэн усанд ордог байсан бол одоо өдөрт 1 удаа халуун усанд орно. Ер нь л их хөлөрнө дөө. Улирал өөрчлөгддөггүй болохоор нэгэн хэвийн мэт уйтгартай санагдаж магадгүй. Гэхдээ хичээл ажилдаа төвлөрч байхад тэрийг тоохгүй дээ.

ХҮНДЭТГЭСЭН,

Т. БИЛГҮҮН (2013 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Миний бие Баттулга овогтой Анужин, Шинэ Эрин сургуулийн гуравдахь төгсөгчдийн нэг билээ. Одоогийн байдлаар Солонгос улсын Seoul National University-гийн хэлний бэлтгэл сурч байгаа бөгөөд ирээдүйд тус сургуульд бакалаврын зэргээр суралцахаар сургууль болон тэтгэлэгийн хөтөлбөртөө өргөдөл явуулсан байгаа. Энэхүү сургууль нь гадаад оюутнуудыг элсүүлэн авахдаа TOEFL IBT шалгалтын 80, IELTS шалгалтын 5.5 оноог шаарддагаас гадна тус сурагчийн 10 жилийн дүнгүүд дээр тулгуурладаг. Тус сурагчийн нийгмийн идэвхи болон сайн дурын ажиллагаанд оролцсон байдал нь Солонгос улсын их сургуулиудад элсэн ороход томоохон туслалцаа үзүүлдэг. Хамгийн чухал нь сурагчийн бичсэн сурах төлөвлөгөө болон өөрийн талаарх эсээ мөн багшийн бичсэн чиний давуу тал зан чанарыг тодорхойлсон захиан юм. Солонгос их сургуулиуд болон Засгийн Газрын тэтгэлэгтэсэнүүдийг хамгийн их чухалчилж авч үздэг. Өөрийн гэсэн зорилготой, тэр зорилгодоо яаж хүрэх вэ гэсэн өөрийн гэсэн төлөвлөгөөтэй хүүхдүүдийг авахыг эрмэлзэлдэг. Дэлхийд эхний 50д ордог сургууль учир тэр хэмжээний их ачаалал өгдөг, тэрэнд бэлтгэлтэй байхад илүүдэхгүй. Гадаад оюутнуудын хувьд Солонгосын Засгийн Газрын тэтгэлэгт сургуульдаа орохоосоо өмнө болон сургуульдаа орсны дараа ч хамрагдах олон тэтгэлэг байдаг.

Амьдрах өртгийн талаар:

Сургалтын төлбөр (1 Семистер) чиглэлээсээ хамааран W2.629.000-W5.074.000 = 5.258.000-10.148.000 MNT Дотуур байр (1 Семистер)- Өрөөнөөсөө шалтгаалан W502000-W1600000= 1004000-3200000 MNT (Дотуур байр нь нийтийн гал тогоотой учир хүсэн хоол хийж идэхэд хэцүү. Гадуур байр хөлсөлж амьдрах сонголт байж болно. Байрны мөнгө дотуур байрныхтай адилхан.

Гэхдээ тог болон интернэтийн мөнгө сар болгон нэмж төлнө. Солонгост байр олох нь хамгийн том асуудал байдаг тул аль болох дотуур байранд орсон нь зүгээр campus дотор ч гадна ч байсан хамаагүй. Campus дотор 10 гаран сургуулийн хоолны газар байдаг бөгөөд энэ нь жирийн хоолны газруудаас хямд байхдаг.

Нэмэлт зүйлүүд:

Утасны дугаараа сургууль дээрээсээ авч болно. Campus нь их том тул бараг campus-аасаа гарах шаардлага гарахгүй. Campus нь уултай залгаа байдаг тул зарим барилгууд нь уулан дээр байдаг, хаана ч гэсэн аюулгүй, цэвэрхэн мөн үзэсгэлэнтэй байгальтай. Сургуулийн автобус нь campus дотроо болон гаднаа үнэ төлбөргүй явдаг. Солонгосд ирсэнийхэ дараа оршин суух эрх аван түүнийхээ дараа банк карт болон даатгал гэх мэт зүйлүүдэд хамрагдах боломжтой. Солонгос хүмүүс найрсаг, хэзээд ч туслахад бэлэн байдаг тул ямар нэгэн асуудал гарвал ойр хавийн хүмүүсээс тусламж авч болно.

Гадаадад суралцах нь амархан зүйл биш учраас миний хувьд аюулгүй, тайван байх нь нэн чухал. Seoul National University нь Солонгосдоо нэгт ордог, өндөр нэр хүндтэй сургууль, Солонгосчууд нь өөрсдөө ч ороход хэцүү, хамгийн чадварлаг хүүхдүүд нь ордог учир энэ сургуульд сурдаг, төгссөн гэхэд хаана ч явсан нэр хүндтэй байна. Сул тал гэвэл хичээлүүд нь Англи хэл дээр орж болох ч профессорууд нь Солонгос хэлээр ярихыг зөвлөдөг учир Солонгос хэл сурах шаардлагатай.

ХҮНДЭТГЭСЭН,

Б. АНУЖИН (2016 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Шинэ эрин сургуулийн 2014 оны төгсөгч Сайнбаярын Золбаяр байна. Төгсөөд МУИС-д 1 жил суралцаад, 2016 оны 3 сараас эхлүүлэн БНСУ-д Korea Aerospace University гэх их сургуульд Aircraft System Engineering чиглэлээр суралцаж байна. Солонгост соёл, хоол гэх зүйлсээс эхлүүлээд өөр болохоор эхэндээ жоохон эвгүй байдаг юм байналээ. Ялангуяа, хэл соёл нь хэцүү санагдсан. Хүндэтгэлийн ярианы хэл, энгийн ярианы хэл гээд байдаг болохоор холиж солиод байдаг юм. Тэрнээс биш бол амьдрах орчин, хүмүүс нь давгүй санагдсан. Санхүүгийн хувьд бол хэрвээ тэтгэлэг аваад стипэнд(stipend) авбал дутахааргүй хангалттай байдаг, бас ажил хийж болоод байдаг болохоор ер нь боломжийн.

Энэ сургуульд хуучин “21-р зуун сан” одоо “ILWOO Foundation” гэх энэхүү сангийн 100% ийн тэтгэлэгтэйгээр суралцаж байна. Энэхүү тэтгэлэг нь жил бүрийн 4-5 сард зарлагддаг ба жилдээ 8 оюутанг (бакалавр - 4, магистр- 4) тэтгэлэгээр суралцуулдаг юм. БСШУЯ-ы сайт болох “www.mecs.gov.mn”-т мэдээлэл нь тавигддаг. Энэхүү тэтгэлэгт хамрагдахад эхлээд бичиг баримтаа бүрдүүлээд бичгийн шалгалт өгнө. Тэнцвэл ярилцлаганд ороод тэнцээд хамрагдачвал бүх юм нь цаанаасаа болохоор виза ямар ч асуудалгүй шууд гарчдаг. Тэтгэлэг олгодог мэргэжлүүд нь гайгүй их ч жил жилдээ тэтгэлэгээр явуулах мэргэжлүүд нь бага багаар өөрчдөгддөг ба ер нь IT, инженер талруугаа байх нь их. Энэ тэтгэлэгийн талаар илүү мэдээллийг БСШУЯамны сайт дээр тавигдсан өмнөх жилүүдийн

мэдээллээс үзээрэй. Солонгост сурахын давуу тал нь миний бодлоор Монголтой харьцангуй ойрхон, Монголчууд ихтэй, ажил хийх, 19 нас хүрчвэл бүх юм нь боломжтой юм шиг, юмны үнэ нь Монголтой гайгүй ойролцоо байдаг санагдсан. Мөн багаар ажиллах, хариуцлагатай байх, биеэ даан ажиллаж суралцах чадвартай байх ёстой. Харин сул тал нь хоол нь жоохон хэцүү байнгын будаа иднэ, мах бараг байхгүй хаха. Өөр шинэ хэл сурч байгаа болохоор Англи хэлээ мартчих гээд байдаг. Одоогоор дөнгөж ирээд 6 сар л болж байгаа болохоор одоохондоо иймэрхүү л байна.

ХҮНДЭТГЭСЭН,

С. ЗОЛБАЯР (2014 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Европд ихэвчлэн Кэмбриджийн А левелийн шалгалтаар хүүхдүүдийг сонгон авдаг учир энэхүү шалгалтад 2 жилийн турш нилээн шаргуу бэлдсэн юм. Энэ шалгалтын талаарх мэдээллийг Cambridge-ийн сайтаас олж болох учраас би тайлбарлах шаардлагагүй байх. Европын сургуулиуд А левелээс гадна нэг шалгалт шаарддаг, тэр нь англи хэлний IELTS шалгалт гэж үзэж байна. Би өөрөө энэ шалгалтыг өгөөгүй. Гэвч энэ шалгалттай адил TOEFL шалгалтыг өгсөн байсан учир өргөдлөө явуулсан сургуулиудтай харьцаж IELTS-ийн оронд TOEFL-ын шалгалтын дүнгээ явуулсан юм.

Миний бодлоор бол хамгийн том хүнд алхам нь өөрийн эсээ байдаг. Энэхүү эсээ нь миний бодлоор "Би хэн бэ?" гэсэн асуултанд хариулсан байх шаардлагатай. Мөн өөр өөр жижиг асуултанд хариулах ёстой: "Ирээдүйд ямар хүн болмоор байна?","Ирээдүйд юу хиймээр байна?" Энэхүү асуултууд нь 10 жилийн хүүхдүүдэд хариулахад маш хэцүү бэрхшээл болдог, гэхдээ заавал даван туулах шаардлагатай.

Европын сургуулиудын А левелын шалгуурууд нь курс болгондоо өөр байдаг. Миний явуулсан сургуулиудын курс нь 3 ширхэг А үнэлгээ шаардаж байсан. Би өөрөө энэ шалгуурт хүрч чадсан учир сургуульдаа тэнцсэн юм. TOEFL-ын хувьд 100 оноо нь авч болох хамгийн доод оноо юм. 100-гаас доош авсан бол дахин өгч 100 оноог давуулахыг бодоорой. Эсээн дээр зөвлөгөө гэвэл: эртнээс өөрөөсөө асуултууд асууж эхэл, туршилтын эсээ маш ихийг бич.

А левелийн шалгалтанд бүхэл бүтэн ном үзэж жилжинийн турш бэлддэг учир хамгийн чухал баримталж явах зүйл нь өөрийн гаргасан жилийн хуваарь байдаг. Ямар хувиурь гаргахаа мэдэхгүй байгаа бол би нэг жишээ хэлье.

Жишээ: А левелийн шалгалтанд 11

дугаар ангийн 9 сард орж хуваарийг бэлдэж эхэлдэг учир өөрийн хуваариа 9 сараас эхлэн 6 сар хүртэл гаргана гэсэн үг. Хуваарь нь тус хүний хурд болон мэдлэгээ хэр ойлгоход тулгуурласан байдлаар гаргана. Миний хувийн хувиар бол 11,12 дугаар жилийн эхний хоёр улиралд тэр жилдээ үзэх номынхоо хэсгийг үзэж дуусгах байсан. Харин тус жилийн сүүлчийн хоёр улиралд нь өгөх гэж байгаа шалгалтуудын өмнөх шалгалтын цаасан дээр ажиллах байсан. Өдөрт хэдэн цаас ажиллахаа өөрсдөө тааруулж хувиараа гаргана. Нэг анхаарах зүйл бий, энэ нь шалгалтын өдөр болох үед тус шалгалтын бүх өмнөх шалгалтуудын цаасыг ажиллаж дууссан байх шаардлагатай!!!

А левелийн шалгалтууд сонгохдоо ямар сургууль руу өргөдлөө явуулахаа шийдсэний дараа сонгоорой. Яагаад гэвэл, буруу хичээл сонгосноос болоод орох хүсэлтэй байгаа курстээ орж чадахгүй байж магадгүй шүү. Түүнээс болгоомжлон орох их сургууль болон сургуулийнхаа курсуудыг сайн судална уу.

Английн ихэнх их сургуулиуд гадаад сурагчдад тэтгэлэгэ өгөх нь ховор байдаг. Гэхдээ Монголын шилдэг 100 сургуулийн Засгийн Газрын Зээл нь надад явах боломжийг олгож өгсөн. Дэлгэрэнгүй мэдээллийг meds.gov.mn-ээс авна уу. Засгийн газрын зээл нь дэлхийн топ 100 сургуулиудад орсон сурагчдад өрсөлдөөнтэйгээр зээл олгодог. Миний хувийн бодлоор бол Монголын ихэнх сурагчид топ 30-д ордог ба засгийн газар нь ч бас тэднээс сонгох нь илүүтэй байдаг. Тиймээс шилдэг 30-д орхыг хичээгээрэй. Ганц зөрүү нь бол А левелийг өгөж их сургуульд орсон бол баклавр түвшнийг 3 жилийн турш судалдаг.

ХҮНДЭТГЭСЭН,

Б. БУДДА (2014 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Намайг Хишигнэмэх гэдэг. Би Шинэ Эрин сургуулийг 2015 онд төгссөн. Одоо Унгар улсын Дэбрэцэний Анагаахааны Их Сургуульд 100% тэтгэлгээр суралцаж байна. Энэхүү захидлаараа дамжуулан дүү нартаа хэрхэн Европын анагаахын сургуульд тэр дундаа Унгар улсад тэтгэлэгтэй тэнцэн суралцах талаар зөвлөгөө өгье. Унгар улс анагаахын чиглэлээр Европдоо төдийгүй дэлхийд дээгүүр үнэлэгддэг. Сургалтын төлбөр, амьдрах зардал гэх мэтчилэн зүйлс нь Америк гэх мэт улстай харьцуулахад хямд байдаг учраас олон орны хүүхдүүд сонгон ирж суралцдаг. Унгар улсад ерөнхий эмч, эм зүйч, шүдний эмч мэргэжлээр англи хэл дээр сургалт явуулдаг 4н анагаахын сургууль байдаг. Уг 4н сургуулийн диплом нь АНУ болон Европд хүлээн зөвшөөрөгддөг.

- Унгарт тэтгэлгээр сурах 2 арга зам байдаг. 1т сургуульдаа тэнцэж ороод голч дүнгээ 4.5-аас дээш хадгалж чадвал 20% буюу жилд \$4000-ийн тэтгэлэг авах боломжтой.
- 2т Унгарын Засгийн Тэтгэлгээр 100% сургалтын төлбөр, сар болгон байр болон бусад зардалдаа 250\$-ын стипенд авдаг. Уг тэтгэлэг нь жил бүрийн 1-3 сарын хооронд зарлагдаж бүртгэл авдаг. (www.meds.gov.mn болон www.tka.hu зэрэг сайтуудаас дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой)

Сургуульд тэнцэн ороход тавих шаардлага сургууль бүр өөр учраас сургуулийнхаа сайт руу орж судлах хэрэгтэй. Ихэнх сургуулиуд элсэн ороход TOEFL- 75, IELTS-5.5-с дээш оноо шаардалагатай. Мөн 2 цаг 30 минутын хими, биологи, физик, анагаахын англи хэл зэрэг хичээлүүдээр бичгийн шалгалт өгдөг. Үүнээс гадна их сургуулийн проффесорууд дээрх хичээлүүдээр аман шалгалт болон ярилцлага авдаг. Шалгалтанд бэлдэхдээ сургуулийнхаа сайт дээр нь тавигдсан сэдвийн дагуу жишиг болгож өгөгдсөн номоос бэлдэж орвол илүү зүгээр. Гэхдээ манай сургуулийн хүүхдүүдийн хувьд AS&A level –р Хими, Физик, Биологийг харьцангуй гүнзгийрүүлэн суралцдаг учраас шалгалтад бэлдэхэд хүндрэл багатай байдаг санагдсан. Манай сургуульд анагаахын 2хон оюутан байдаг, ирээдүйд бүр олон болно гэж найдаж байна. Та бүхэнд амжилт хүсье!

ХҮНДЭТГЭСЭН,

Н.ХИШИГНЭМЭХ (2014 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Намайг Магад-Үнэнгийн Билэгдэмбэрэл гэдэг. Би Шинэ Эрин сургуулийн анхны 2014 оны төгсөгч. Одоогоор Бүгд Найрамдах Унгар улсад химийн инженерийн мэргэжлээр Будапештийн Технологи Эдийн Засийн их сургуульд сурдаг.

Унгар улс нь Европын холбооны улс ба бух олон улсад зөвшөөрөгдсөн шалгалтуудыг хүлээж авдаг. Ерөнхий их сургуулиуд нь харьцангуй бага шалгуур үзүүлэлт оюутнууддаа тавидаг боловч бүрэн дунд боловсролын эсвэл бакалаврийн дипломийн дүн голч, мөн англи хэлний мэдлэгийн шалгалтуудын оноог түлхүү анхаарч харж шалгаруулалтаа хийдэг. Бараг бух Унгарийн их сургуулиуд бакалаврийн зэрэгт оюутнуудаас элсэлтийн шалгалт авдаг. Тэр нь мэргэжилтэй нь холбоотой хичээлүүд байх болно. Хэрэв, Англи улсын А-лэвэл-ийн шалгалтуудын Б болон түүнээс дээш дүнтэй бол, элсэлтийн шалгалтаас чөлөөлж өгдөг.

Унгарын их сургуульд элсэж орохын хамгийн бага байж болох шалгуурууд гэвэл дундаж голчтой бүрэн дунд боловсролийн гэрчилгээ эсвэл дипломийн голч оноо болдог. IELTS-ийн шалгалтад нийт үзүүлэлтээр Банд 6-тай байж хэлний шалгуур үзүүлэлтэд тэнцэнэ, хэрэв та англиар сурахыг хүсвэл. Ямар ч их сургуулид, унгар хэлээр суралцах боломжтой бөгөөд хэрэв хэзээ ч унгар судалж байгаагүй бол заавал ч үгүй 1 жил хэлний бэлтгэлд суух шаардлагатай. Хэрэв англи хэлээр Унгар улсад боловсрол эзэмшихийг хүсвэл мэдээж тодорхой сайн түвшний академик болон ярианы англи хэл шаардлагатай. Энэ улсад бараг бүх профэссор, докторууд маш өндөр англи хэлний түвшинтэй байдаг.

Олон улсын шалгалтууддаа хамгийн багадаа C дүн авах хэрэгтэй. Мөн мэргэжлээс хамаарч, анхнаасаа хичээл

сонголтуудаа зөв тунгааж шийдэх хэрэгтэй.

Унгар улсын бух томоохон хотууд өөрсдийн гэсэн нэр хүндтэй, том их сургуулиуд институтуудтай байдаг. Нийсэл хот Будапешт-ээс харьцангуй хүн ам цөөхөнтэй, жижиг Дэбрэсэн гэх өөр хотод ч сурахад оюутнуудад амьдрах сурах бүх орчин маш дөхөм, боломжийн байдаг. Өөрийн хувийн амьдралын хэвшил сонголтоос хамааран их хотын төв нийслэл эсвэл өөр илүү хөл хөдөлгөөн багатай, намуухан хотод сонголтоо хийж болно. Ямар ч том хотод нь очиж сурсан тэндээ ердөө нэг жилийн дотор үнэхээр хурдан дасаж, тухайн орныхоо түүх соёлоос улам ихийг сурч мэдэж авдаг. Зам тээврийн хувьд ямар ч төөрч будилах асуудалгүйгээр, очих газраа маш дөт очиж чаддаг. Бүх автобус, трамбайний буудлууд дээр нь тухайн буудлын нэр, бух явдаг чиглэл болон тэдгээрийн цагийн маршрут байдаг. Нэг удаагийн тасалбар нь харицангуй унэтэй, ойролцоогоор 2500 төг орчим байдаг учир аль болох хурдан тухайн сардаа сарын оюутны билетээ авах хэрэгтэй. Унгарт их олон оюутнуудад зориулсан үдэшлэг, соёлын болон танилцах арга хэмжээ олонтаа явагддаг. Ялангуяа Будапештэд, өдөртөө ч шөнөд нь хөл хөдөлгөөн амьдрал үл зогсоно. Ямар ч орой найзуудтайгаа орой цуг гарахад, орж үзээгүй шинэ рэсторан гэх мэт олон боломжууд гарч ирдэг. Мөн Унгарт хүмүүс их дугуй унаж, паркаар алхах дуртай байдаг. Энд ямар ч хотод олон томоохон цэцэрлэгт хүрээлэнгүүд байдаг. Тэнд хумуус нохойгоо салхилуулах, хос залуус болзоонд алхах, модний доор ном уншин хэвтэх, гуйлтийн улаан зам дээгүүр гуйх гэд бүх сайхан боломжууд бүрдсэн байдаг. Ямар ч асуудал тулгарсан ч тухайн өөрийн их сургуулийнхаа гадаад оюутнуудыг хариуцсан хүнтэй холбогдоход бүх зөвлөгөө мэдээлэл тусламжийг элэгсэгээр өгдөг.

Төв Европын бусад орнуудтай харьцуулахад, амьжиргааны өртөг Унгарт хамаагүй бага байдаг. Гэхдээ хотын хаана байх байршлаас хамаарч байрний түрээсийн төлбөр өөр өөр байдаг. Ерөнхийдөө оюутны байранд амьдрах нь байр түрээсэлснээс хямд тусдаг. Хоол ундний хувьд, унэ өртөг нь манай улстай их ойролцоо ба жимс жимсгэнэ цоо шинээрээ ч их хямд байдаг. Хот дотор нэг газраас нөгөө газрын хооронд явахийн хувьд оюутны сарийн билетээ авчихсан байхад дуусах хугацаа хуртлээ хэдэн ч удаа хуссэнээрээ ашиглаж болно. Бүгд найрамдах Унгар улс нь өөрсдийн засгийн газрийн зүгээс тодорхой жагсаалтанд багтсан орны оюутнуудад тэтгэлэг жил болгон олгодог. Хоёр орны гэрээнээс хамаарч тухайн жил авах оюутны тоо эрс өөр өр ялгаатай байж болно. Тэтгэлэг нь бүрэн сургалтийн зардал, оюутны байр, эрүүл мэндийн даатгал зэргийг даахаас гадна 140 Доллар орчим стипенд сар болгон олгодог. Ирж буцах онгоцний зардал, өөр бусад хэрэглээний нэмэлт зардлыг оюутан өөрөө бүрэн санхүүгээрээ хариуцах хэрэгтэй байдаг болно.

Тухайн миний сурдаг жил Унгар улсийн засгийн газрийн тэтгэлэг зарлагдсан бөгөөд эхлээд Боловсролын Яамны хүнд бүх цаанаас хэрэгтэй гэсэн материалүүдыг жагсаалтийн дагуу бүрдүүлж илгээсэн. Дараагаар нь тэтгэлгийн website-нд цахимаар бүртгүүлж, мэргэжил болон боломжит өөрийн хусэж буй гурван их сургуулиа сонгосон. Тухайн тэтгэлэг өгдөг Tempus Public Foundation гэх байгууллага хэсэг хугацааны дараа бүх оюутнуудийн материалыг нарийн судалж нягталсний эцэст яг хэдэн оюутанд тэтгэлэг өгөх, хэн хэн тэтгэлэгт тэнцсэнийг илтгэж мэдээллэдэг. Дараагаар нь их сургуулиадтайгаа холбоо барьж, тэдгээрийн шаардлага үзүүлэлтэд тэнцэж тухайн их сургуульд сурах урилгаа авах хэрэгтэй. Их сургуулын урилга болон тэтгэлэгийн гэрчилгээ хоёр дээрээ холбогдох өөр бичиг баримтуудыг бүрдүүлж виза мэдүүлэх эрхтэй болдог. Виза амжилттай авсны дараагаар Унгар улсад очиж тухайн хот дахь өөрийн их сургуульдаа бүртгүүлснээр сурах гараа бүрэн нээгдэж байгаа хэрэг юм.

Шэнгэний визатай учир өөр маш олон европийн холбооны улс гүрнүүд руу чөлөөтэй аялж зорчих үүд хаалга нээгддэг. Цаг агаарийн хувьд их тогтуун, үнэхээр цэвэр сайхан агаартай. Бүх хүнд хэрэгтэй зүйлсийг хүмүүсийнхээ төлөө бүрдүүлж өгсөн байдаг. Олон том бренд-ийн дэлгүүрүүд, хоолны газрууд, цэцэрлэгт хүрээлэн гээд цагаа чөлөөт цагаа өнгөрөөх газрууд бүгд нээлттэй элбэг. Ямар ч Унгар хүнээс хаашаа явах талаар туслалцаа хүсэхэд чин сэтгэлээсээ тусалж өгдөг. Мөн бүх газруудад таних хүмүүс ч гэсэн бие биетэйгээ их мэндчилж, хаалга бариж зогсож нөгөө хүнийгээ эхэлж гаргах эсвэл оруулдаг соёлтой. Сургалтын чанарын хувьд асар өндөр бөгөөд ихэнх багш, проффэссорууд бүгд докторын зэрэгтэй, мэргэжлээрээ олон судалгаа шинжилгээний ажил хийсэн байдаг. Жишээ нь миний суралцдаг Будапэшт-ийн технологи эдийн засгийн их сургууль нь Унгартаа эртний түүхтэй, нэр хүндтэй ба олон Нобэл-ийн шагналтнуудийг төрүүлсэн байдаг. Олон тивийн өөр орний оюутнуудтай хамт суралцахийн зэрэгцээ үзэсгэлэнт Унгарын соёл урлаг, аж ахуйтай танилцах нь насан туршийн мартагдашгүй ав хөрөнгө, дурсамж болно гэдэгт би итгэлтэй байна

Унгар нь хэдий өндөр хөгжилтэй орнуудын жагсаалтанд ордог боловч, энд дундаж цалин харицангуй бага ба амиа хорлолтын зэрэг өндөр байдаг. Шөнө орой ганцаараа гарахад, харьцангуй бараг аюул багатай ч Унгарт олноор суурьшдаг циганчуудаас хол явах хэрэгтэй. Учир ни тэд асар их гуйлга гуйж, худал яриж, эд зүйлс хулгайлахаараа алдартай бад тэдэнд ер нь огт итгэл өгөөд ерөөсөө нэмэргүй. Ерөнхийдөө унгарууд маш тусч, агуу ард түмэн боловч Европтоо харьцангуй арьс өнгөөр бага зэрэг ялгаварлаж, их гомдлож, уух ерөнхий чиг хандлагатай байдаг.

ХҮНДЭТГЭСЭН,
М. БИЛЭГДЭМБЭРЭЛ (2013 ОНЫ
ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Чех улс боловсролын салбраараа Европд олон зууны өмнөөс алдаршсан бөгөөд олон тооны их сургуулиуд маш өргөн хүрээг хамарсан мэргэжлийн хичээлүүдийг оюутан бид нарт санал болгож байдаг юм. Их сургууль тус бүр өөрийн гэсэн шалгууртай байдаг ба тэдгээрийг нь их сургуулийнхаа албан ёсны сайтаас хялбархан олох боломжтой.

Ерөнхийдөө Чех их сургуулиудыг шалгаруулалтын тал дээр 2 хуваж авч үзэж болно. Эхний төрөлд нь барууны улсуудын шалгаруулалттай төстэй буюу элсэлтийн шалгалтны шаардлагагүй шалгаруулалттай сургуулиуд багтана. Эдгээр нь суралцах хүсэлтэй байгаа оюутнуудад зориулж хэрэгцээтэй материалын жагсаалт болон хүлээн авах хугацааг заасан байна. Ихэвчлэн эдгээр сургуулиуд нь TOEFL болон IELTS-ийн оноо, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, тодорхойлолт зэрэг материалуудыг шаардана. Заасан материалуудыг бүрдүүлж явуулаад тэнцсэн тохиолдолд сургуулийн урилга ирэх бөгөөд энэ нь урт хугацааны визны материалын шаардлагад нийцнэ.

Дараачийн шалгаруулалтын төрөл нь элсэх хүсэлтэй байгаа оюутнуудаас элсэлтийн шалгалт өгөхийг шаарддаг юм. Ихэвчлэн техник болон технологийн нарийн мэргэжлийн их сургуулиуд энэ төрлийн шалгуурыг тавьдаг бөгөөд үүний шалтгаан нь уг сургуулиудыг баклавын зэрэгт суралцах хугацаа нь 6 семестр тул оюутнууд суурь сайтай байж байж ямарваа бэлтгэл ерөнхий программын шаардлагагүйгээр шууд мэргэжлийн хичээлд орох түвшинд байна уу эсэхийг шалгахад оршино. Энэ шалгаруулалт нь бага зэрэг ярвигтай санагдах магадлалтай учир нь сургуульдаа тэнцхийн тулд оюутан эхлээд материалаа шуудангаар явуулж шалгалтны урилга авна. Шалгалтны урилгаараа богино

хугацааны виз авч очин шалгалтаа өгнө. Тэнцсэн тохиолдолд их сургуулийнхаа урилгыг авч эх орондо буцаж ирэн дахин урт хугацааны визэнд материалаа өгөх шаардлагатай болдог. Чехийн визны цаг их ховор олддог учир энэ нь зарим тохиолдолд асуудал үүсгэх нь бий. Гэсэн хэдий ч суралцхыг хүссэн мэргэжил нь өөр улс орнуудад болон өөр их сургуулиудад олддоггүй эсвэл ховор байдаг тул оюутнууд уг ажиллагаатай процессыг үл харгалзан сурах зорилгодоо үнэнч зүтгэдэг юм. Чех их сургуулиудад чех болон англи хэл дээр суралцах боломжтой байдаг ба хэлний мэдлэгийн шаардлагууд бий. Эдгээр нь TOEFL-ийн 90, IELTS-ийн 6, Чех хэлний CCE шалгалтны B2 түвшнийг хангасан байхыг шаарддаг. Санхүүгийн тал дээр Чехд суралцах их амар, учир нь тус улс нь Европтоо өртөг багатайд ордог. Хүнс болон байрны үнэ хямд, эрүүл мэнд аюулгүй байдлыг ч мөн сайн хангасан байдаг.

Их сургуулиудад Чех хэл дээр сурах тохиолдолд ихэвчлэн үнэгүй байдаг. Англи хэл дээр сурахад төлбөртэй бөгөөд энэ нь тухайн сургууль болон мэргэжлээсээ хамааран их ялгаатай байна. Мэргэжлээс хамааран оюутнууд Erasmus Mundus эсвэл засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой. Бакалаврын тэтгэлэг ховор байдаг гэж чехүүд өөрсдөө хэлдэг бөгөөд оюутнуудад үзүүлдэг санхүүгийн дэмжлэг нь голцуу хямд байр, унаа болон хоол, хэрэгцээний зүйлсд үзүүлэх хөнгөлөлтийн хэлбэрээр явдаг гэдэг.

ХҮНДЭТГЭСЭН,

Б. АНУ (2016 ОНЫ ТӨГСӨГЧ)



Намайг Сангибат овогтой Мөнхсолонго гэдэг. 2011 оны 11 сард миний бие Шинэ Эрин сургуульд анхны 40 сурагчдын нэг болж элсэж байв. Энэ үед Шинэ Эрин бусад сургуулиас ямар ялгаатай, ямар зорилготой, юугаараа шинэлэг, юугаараа намайг сорих талаар ямар ч ойлголтгүй байсан. Харин 4 жилийн дараа би зорилготой, мөрөөдөлтэй түүндээ хүрэхийн тулд цаашдын алхамуудыг хийж чадах мэдлэг боловсролтой хувь хүн болж төлөвшсөн байсан нь Шинэ Эрин сургуулийн надад өгсөн хамгийн том боловсрол байлаа. Харин миний хувьд сургуулиа төгсөөд мөрөөдөлдөө хүрэх анхны алхам бол их сургуульд элсэн орох байв. Ингээд гадаадын их сургуульд элсэн орохоор төлөвлөж байгаа сурагчиддаа өөрийн туршлага, бяцхан түүхүүд мөн түүн дээр суурилан зөвлөмж бичлээ.

Би 2015 онд Канад улс дахь Ванкувер хотын Fairleigh Dickinson их сургуульд элсэн орсон бөгөөд одоогоор 2 дахь жилдээ суралцаж байна. FDU нь АНУ, Англи, Канад гэсэн 3 улсад үйл ажиллагаагаа явуулдаг хувийн их сургууль бөгөөд 1942 онд анх байгуулагдаж, олон улсын оюутнуудыг хүлээн авдаг АНУ-н анхны сургуулиудын нэг болж байжээ. FDU Нэгдсэн Үндэсний Байгууллагатай байгуулагдсан цагаасаа эхлэн харилцан холбоотой ажжиллаж ирсэн бөгөөд оюутнуудад тэтгэлэг олгох, НҮБ-д дадлага хийх, олон улсын димпломатуудтай биеээр болон интернэтээр холбогдож өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудын тухай ярилцах гэх мэт олон боломжийг олгодог. Ванкувер хот дахь их сургуулийн байр харьцангуй жижиг хэмжээтэй бөгөөд

цөөн сурагчдийг Олон улсын бизнес, Мэдээллийн технологи, Зочид буудлын мэнежмент гэсэн мэргэжилүүдэд төвлөрөн мэргэшүүлдэг.

Энэхүү сургуульд ороход надад:

1. Англи хэлний түвшин тогтоох шалгалт
2. Ерөнхий боловсролын сургуулийн дүнгийн голч
3. 2 ширхэг Recommendation Letter буюу чиний давуу тал зан чанарыг тодорхойлсон захиа
4. Application form буюу элсэлтийн өргөдөл

Тэтгэлэг авахад:

1. Тэтгэлгийн өргөдөл дотроо тэтгэлгийн зохион бичлэг, асуулт хариулт
2. SAT-н шалгалт
3. A level-н шалгалт гэх зүйлүүд хэрэг болсон.

Америк болон Канадын их сургуулиудад суралцахад хамгийн эхний шалгуур хэлний мэдлэг байдаг. Англи хэлний бичгийн, уншлагын, ярианы болон сонсох чадварыг шалгадаг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон шалгалт байдгийг та бүхэн мэдэх ба түүнээс TOEFL IELTS шалгалтыг энэ орднуудад хүлээн зөвшөөрдөг. Тиймээс эдгээр шалгалтуудад эртхэнээс бэлдэж эхлэх тусмаа илүү сайн үр дүн үзүүлнэ. Хамгийн түрүүнд орох гэж байгаа сургууль чинь аль шалгалтыг хүлээн зөвшөөрдөг талаар олж мэдээд, шалгатуудын талаар мэдээлэл цуглуулж интернэтэд олноороо байдаг дасгал шалгалтыг хийж үзээд аль нь чиний сурах болон шалгалт өгөх арга барилд илүү нийцэж байгааг олж мэд. Жишээ нь: Хэрвээ чи хүнтэй англиар

ярихдаа ганцаараа буюу дэлгэцтэй ярьснаас илүү итгэлтэй байж чаддаг бол IELTS-ийн шалгалт оновчтой гэх мэт. Энэ 2 шалгалтын түвшин яг адил боловч судалгаа хийснээр аль шалгалт нь чамайг хэдийн байгаа мэдлэгээ илүү харуулах боломж олгох вэ гэдгийг олж мэдэх юм.

Дараагийн алхам сонгосон шалгалтандаа тууштай бэлдэх. Шалгалтанд бэлдэхэд заавал сургалтанд суух шаардлага байдаггүй. TOEFL-ийн шалгалтыг өгөхөөр зориж байгаа төгсөх ангийн сурагч чамд мэдээж өөрөө бие дан суралцахад хангалттай хэмжээний хэлний мэдлэг, бие даан суралцах арга барил суусан байх учиртай. Сургуулиудад өргөдөл явуулж шалгалтууд өгөхөд зардал ихтэй байдаг тул найз нөхөдтэйгөө зорилго тавин хамт бэлдсэнээр сургалтанд суух мөнгөө өөр олон сургуульд өргөдөл явуулахад зарцуулах боломжтой болно. Найз нөхөдтэйгөө гэсний учир нь чамд мэдээж мэдэхгүй ойлгохгүй юм гарж л таараа, тэр үед найзуудтайгаа хамтран хийснээр бусдын туршлагаас сурах, хүнд зааснаар илүү сайн ойлгох, хамтдаа яриагаа бэлдэх, бие биедээ урам өгөх гэх мэт олон тус дэмтэй. Миний хувьд найзуудтайгаа Шинэ Эрин сургуулийнхаа номийн санд эсвэл ангидаа англи хэлний багш Rhonda Desrochers-той бэлддэг байсан.

Өөрийн туршлагаас хэлэхэд, хүссэн сургуульдаа элсэн орохдоо application буюу өргөдлөө хэдэн сард өгсөн байх ёстойг олж мэдээд тэр хугацаанаасаа дор хаяж 3 сарын өмнө шалгалтаа өгөх нь зүйтэй. Би тэр талаар тооцоолоогүйгээс болж бүтэн жил алдаж байсан удаатай. TOEFL-ийн шалгалтын хариу дунджаар 10-14 хоногийн дотор ирдэг боловч би эхний шалгалтын хариугаа 2 сар хүлээж байсан. 2 сарын дараа шалгалтын хариу "Уучлаарай техникийн алдаа гарсантай холбогдуулан таны ярианы шалгалтын оноог дүгнэх

боломжгүй болсон бөгөөд шалгалтын хариуг гаргах боломжгүй боллоо, та дахин шалгалт өгнө үү" гэсэн хариу ирж байсан. Ингээд намайг хариугаа 2 сар хүлээж дахин шалгалтын хариугаа авах гэж сар хүлээж суутал хүссэн сургуулийн маань элсэлт авах хугацаа дууссан. Тиймээс дор хаяж 3 сарын өмнө шалгалтаа өгөх нь техникийн алдаа гарсан, захиа нь алдагдсан, саатсан эсвэл хүссэн хэмжээндээ хүртэл өгч чадаагүй байсан ч чамд дахин нэг оролдоод үзэх хугацаа болон боломжийг өгч байгаа юм.

Мэдээж ерөнхий боловсролын сургуулийн голч үнэлгээ маш өндөр буюу дор хаяж 85%-с их эсвэл 3-3.5 байх хэрэгтэй тул хичээлүүд дээрээ аль болох өндөр оноо авахыг хичээх хэрэгтэйгээс гадна хичээлүүдээ маш сайн ойлгох хэрэгтэй. Учир нь эдгээр нь их сургуульд ороход эргээд хичээлүүдийн чинь үндэс болдог.

Recommendation Letter буюу чамайг тодорхойлсон чиний давуу талуудыг бичсэн багш болоод дотны хүмүүсийн захиа. Энэ захианд чамайг хувь хүн талаасаа ямар зан чанартай, давуу болон сул талууд, академ буюу хичээлдээ сайн муу талаарх, сурах арга барилаа олсон эсэх, сургуулиас гадуурх үйл ажиллагаанд хэрхэн оролцдогоос эхлээд удирдан манлайлах, хүний итгэл даах чадварыг хүртэл дүгнэн бичсэн захидал байдаг. Тиймээс чамайг илүү сайн мэддэг, үнэлдэг багш, сургуулийн удирдлага эсвэл хичээлээс гадуурх оролцсон үйл ажиллагаа, клубын чинь удирдагч бичсэн байвал зохимжтой. Үүнээс гадна эдгээр захиа хэрэгтэй гэдгийг захиа өгөх хүндээ эртнээс хэлэх нь завгүй багш нарын татгалзах хариунаас сэргийлэх бөгөөд тухайн хүнд чамайг ажиглах болоод чиний тухай үнэн зөв дүгнэлт өгөх боломжыг олгодог.

Элсэлтийн өргөдөлийн гол зорилго нь та бүхний мэдэж байгаагаар чиний тухай танин мэдэх юм. Өргөдөл нь чиний сурж

байсан сургуулиудаас эхлээд ямар хичээлд дуртай, ямар сонирхол, хүсэл мөрөөдөлтэй гээд олон асуултыг асуух ба ихэнх тохиолдолд олон сэдвүүдээс сонголтоо хийн эссэ бичүүлдэг нь чамайг хэн бэ гэдгийг танин мэдэх зорилготой. Эссэгээ мэдээж эртнээс маш нухацтай бодож, чанартай, ухаалаг мөн зөвхөн өөрийнхөө дотоод ертөнцийг гаргаж бичих нь чухал.

Эссэнээс гадна элсэлтийн өргөдөлд нөлөөлөх гол зүйл нь хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хэрхэн оролцдог байсан түүх. Тиймээс аль болох олон соёл урлаг, спорт, олон улсын тэмцээн уралдаан, буяны үйл ажиллагаанд оролцож түүндээ тэргүүлэгч байж амжилт гаргахыг зорих хэрэгтэй. Ингэснээр тэд чамайг зорилготой, сурах хүсэл эрмэлзэл, өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой хүн гэдгийг харна. Хэрвээ үнэхээр л ихээр сурахыг хүсэхгүй бол чи бусад олон оюутнуудаас юугаараа ялгарна гэж?

Миний хувьд 11-р ангийн төгсгөл болон 12р ангидаа их сургуулиа төлөвлөж зорилго тавьж эхэлсэн нь олон талаараа дутагдалтай байсан. Төгсөлтийн шалгалт, Монгол улсын элсэлтийн шалгалт, A level-н шалгалтын бэлтгэл, TOEFL, SAT дээрээс нь сургуулиудад өргөдлөө илгээх гэх мэт олон зүйлийг маш богинохон хугацаанд хийх хэрэг гарсан тул мэдээж замбараагүй бөгөөд ачаалал ихтэй байсан. Тиймээс их сургуульд ороход дор хаяж 2 жилийн өмнөөс бэтгэх хэрэгтэй ба бүх зүйлийг дараалал, төлөвлгөөтэй хийх шаардлагатай. Маш их судалгаа хийж яг юу хэрэгтэй талаар нарийн жагсаалт гаргаж, зорилго тавьж түүндээ хүрэхийн тулд тууштай хичээх хэрэгтэй.

Хамгийн чухал нь гадаадын чанартай их сургуульд орох нь чи зөвхөн ЧИ өөрийнхөө ирээдүйн төлөө гаргаж байгаа шийдвэр гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Гадаадын их сургуульд суралцах нь зөвхөн

өндөр мэдлэг боловсролтой оюутан болох ч биш цаашлаад өөртөө итгэлтэй бие даасан хувь хүн, дэлхийн иргэн болох боломжийг олгодог. Шинэ Эрин сургууль надад гадаад улсад сурч боловсрон, олон улсын оюутнуудтай уулзаж тэдний соёл, бодол санаа, амьдрал болон аливаа юмыг харах өнцөг цаашлаад хорвоо дэлхийг болон өөрийгөө танин мэдэх үүд хаалгыг нээж өгсөн. Энэ үүд хаалга чамд нээлттэй байна.Одоо тэр хаалгаар орохын тулд чи юу хийж чадах вэ?

ХҮНДЭТГЭСЭН,

С. МӨНХСОЛОНГО (2013 ОНЫ
ТӨГСӨГЧ)



Намайг Энхтөрийн Баярмаа гэдэг ба Шинэ Эрингийн 2014 оны төгсөгч. АНУ-ын Колорадо Коллежид эдийн засаг болон герман хэл судлал гэсэн мэргэжлээр суралцаж байгаа. Эх орныхоо түүх соёлоор бахархаж, ирээдүйн сайн сайхан, хөгжилд нь маш их итгэдэг. Эдийн засагч мэргэжлээр суралцаж байгаагийнхаа хувьд Монгол орныхоо олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, санхүү эдийн засгийн тогтвортой хөгжлийг нь хангах ирээдүйн эрч хүчтэй шинэ үеийн боловсон хүчний нэг байхыг эрмэлздэг. Чөлөөт цагаараа би зураг зурах, загварын сэтгүүл унших, шинэ газар, орноор аялах дуртай.

Ямар шалгалтууд өгч, юу юу бэлдсэн бэ ?

АНУ-ын их сургуульд сурна гэдэг хүсэл маань 9, 10 дугаар ангиас л эхэлсэн дээ. Багадаа Америкт амьдарч байсан болохоор Америк соёл, амьдралын хэв маяг, хүмүүс нь нэг л дотно, яг л хоёр дахь гэр шиг минь санагддаг юм. Тийм болохоор хэдий аав ээжээсээ холдож үзээгүй, дөнгөж 10 жилээ төгсөх гэж буй жоохон охин байсан ч очих газар минь сэтгэлд ойрхон байсан болохоор би үүнийг чадна гэдэгтээ итгэлтэй байж чадсан. Түүнээс гадна дэлхийд тэргүүлдэг Америкийн дээд боловсролын чанар, ялангуяа liberal arts систем буюу мэргэжлээсээ гадна шинжлэх ухаан, соёлын маш олон салбарыг өөрийн сонирголоороо судлах боломж, тэр бүхэн бүгд миний сонирхолыг ихэд татаж байсан. Тэгээд өөрийнхөө урд тавьсан том зорилгоо биелүүлэхийн тулд би маш их судалгаа хийж, их ч хөдөлмөрлөсөн.

Хүн дуртай юмаа нээрээ л дуртай хийдэг юм билээ. Хичнээн их даалгавар, AS, A level-ийн шалгалттай байсан ч би илүү холыг харахыг хичээн, сургуулиа судлах цаг заавал гаргадаг байлаа. АНУ-ын шилдэг сургуулиуд ямар оюутнуудыг яаж шалгаруулж, сурах орчингоо хэрхэн бүрдүүлж байна вэ, би элсэн орсноороо ямар давуу талуудыг эдлэх талаар уншиж, за тэгээд сургуулиудаа орох магадлал, тэтгэлэгийн хэмжээ, шалгуурууд зэргээр нь хуваагаад судалж гардаг байв. Ингэж зорилгодоо хүрэхийн тулд их мэрийсний эцэст төгсөх жилийнхээ эхний хагаст TOEFL, SAT, SAT Subject Test шалгалтуудаа өгөн, бүх эссэнүүдээ бичиж, application-оо явуулсан.

SAT-н том цэнхэр номыг ажиллаж суухдаа оноогоо ахиулж чадахгүй үедээ ч юм уу эссэнүүдээ дахин дахин бичих үед мэдээж шантрах үе зөндөө гарч байсан. Бас Харвардын Билгүүний блогийг уншаад эсвэл Ivy League-үүдийн подкастыг сонсоод догдлоод унтаж чадахгүй байсан өдрүүд ч байлаа. Гэхдээ эргэж хараад би та бүхэнд зөвлөхөд өөр дээрээ хэт их дарамт тавиад хэрэггүй гэж хэлмээр байна. Зүгээр л эртнээс сайн төлөвлө, тэгээд чадах бүхнээрээ хичээ. Юу хэрэгтэй, юу хэрэггүйг ялган, цаг заваа үр дүнтэй ашиглаж, өөр хэн нэгэнд найдаж суулгүйгээр юм бүхэн чамаас л шалтгаална гэдгийг ухамсарлах хэрэгтэй. Ахлах ангидаа тэгж чадвал чи хүссэн сургуульдаа орж л таараа.

Хамгийн бага шаардлага нь юу вэ?

Дүнгээ аль болох өндөр байлгах хэрэгтэй. Бас дуртай зүйлээ хөгжүүл. Спортоор хичээллэдэг ч юм уу эсвэл

маш гоё урлагын авьяастай бол тэр зүйлээ хичээл ихтэй байна гээд бүү хая. Энэ авьяас эсвэл сонирхол чинь дээд сургуулийн элсэлтийн мэргэжилтэн байтугай бусад олон хүмүүст сонин санагдахаас гадна чөлөөт цагаа зөв, үр дүнтэй өнгөрүүлэх боломж юм. Ер нь Америкийн сургуулиуд дан хичээлээс өөр юм хийдэггүй эсвэл их авьяаслаг хэрнээ акедемик талаа орхигдуулсан хүүхдээс илүүд well-rounded буюу бүх талаараа өрсөлдөх чадвартай хүүхдийг илүүд үнэлдэг. Хэлний болон SAT, ACT шалгалтуудын хувьд ихэвчлэн сургуулиасаа л шалтгаална. Мэдээж оноо өндөр бол сайн, учир нь өндөр шалгууртай сургуулиуд ихэвчлэн өндөр тэтгэлэгтэй байдаг.

Оюутны амьдралыг ерөнхийд нь тайлбарлавал (хүмүүс, амьдрах орчин гэх мэт)

АНУ-ын их сургуулиуд сургалтын төлбөрийн хувьд дэлхийд хамгийн өндөртөө ордог. Түүнийгээ дагаад хангамж маш сайн. Хичээл, хоол орон байр, бие болон сэтгэлзүйн эрүүл мэнд, чөлөөт цагаа өнгөрүүлэх зүйлс гэх мэт бүхий л талаар маш сайн дэмжиж өгдөг. Хэрэгтэй бүх зүйл чинь хэдэн минут алхаад орчихож болохоор хэмжээний ойрхон, campus дээрээ төвлөрсөн байдаг болохоор анхаарлаа зөвхөн хичээлдээ хандуулах боломжийг маш сайн бүрдүүлсэн гэсэн үг. Миний сурч байгаа сургууль жижиг, сургууль учраас нэг хичээлд суух оюутны тоо 25-аас хэтрэхгүй. Тийм болохоор профессорууд минь намайг нэрээр минь дуудаж, Монголоос ирсэн гэж мэднэ, бас ангиараа профессорындоо очиж хоол идэх ч үе зөндөө байна. Хичээлээсээ тодруулах зүйл байвал, эсвэл карьерийн зөвлөгөө авмаар байвал, ер нь ямар ч үед тэд туслахад бэлэн, яг найз шиг нээлттэй байдаг нь бусад том university-нуудаас давуу талтай.

Ямар тэтгэлэг авсан бэ, бас бусад сурагчид яаж авч болох вэ?

Би маш өндөр хэмжээний тэтгэлэг авч чадсан, миний сургалтын төлбөр, байр хоол гэх мэт ороод. Миний өмнө хэлсэнчлэн сургуулиа сайн судлаад, явуулах формуудаа анхааралтай цагт нь гүйцэтгэж явуулбал тэтгэлэг авах боломжтой.

Сурж буй улсын тань давуу тал юу вэ?

Боловсролын чанар, liberal arts education буюу маш өргөн хүрээний боловсрол, материаллаг хангамж болон төгсөгчдийн хүрээ нь Америкийн боловсролын хамгийн том давуу талууд гэж бодож байна. Харин нийтэд нь хөгжилтэй оронд суралцахын давуу тал гэх юм бол хувь хүний хувьд бие дааж, нүд тайлан, өөртөө маш их хөрөнгө оруулалт хийж байна гэсэн үг. Үүнээс гадна гадаадад явахаар хүн улам бүр эх орноо гэсэн бодолтой болдог юм шиг.

Сурж буй улсын тань сул тав юу вэ?

Гэрээ санах, эсвэл монголд танил хүнгүй, найз нөхөдгүй болоод байх шиг санагддаг боловч эдгээр маань давуу талуудтайгаа харьцуулахад даваад гарчих амархан зүйлүүд шүү дээ. Зундаа гэртээ ирж болно, эсвэл АМОХ гэх мэт холбоонуудад орох гэх мэтчилэн.

ХҮНДЭТГЭСЭН,

Э. БАЯРМАА (2014 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Сайн байна уу? Шинэ Эрин сургуулийн 2014 оны 12Б ангийн төгсөгч Моломжамцын Мандхай байна. Би 2014 оноос АНУ-н Миннесота мужын Inver Hills Community College-д элсэн суралцаж 2016 онд төгссөн бөгөөд University of Minnesota, Twin Cities -д 3-р курсээсээ шилжин Биохими-н мэргэжилээр суралцаж байна. Миний хувьд community college-р дамжин их сургуульд шилжин орох нь санхүүгийн хувьд болон Монголын сургалтын системээс Америкийн сургалтын системд шилжин дасах, бие даан амьдарч эхлэх болон хэлний мэдлэгээ сайжруулах зэрэгт дасахад хэрэгтэй санагдсан.

Анх коммунити коллежид ороход IELTS-с өөр шалгалт өгөөгүй боловч сургуульд элсэх өргөдөлдөө (application)-дээ A, AS-level, IGCSE сертификатуудаа хавсарган явуулсан. Коллежид ихэвчлэн ерөнхий эрдмийн хичээлүүд болон их сургуульд шилжин суралцахад зайлшгүй үзсэн байх ёстой хичээлүүд үздэг. Эдгээр хичээлүүдээ ихэвчлэн 2 жилд үзэж дуусдаг бөгөөд цааш өөрийнхөө шилжин суралцахыг хүссэн сургуулидаа дахин application бөглөж явуулдаг. Ингэхдээ ямар нэг нэмэлт шалгалт (TOEFL, SAT) өгөх хэрэггүй байдаг, учир нь коллежид дээд түвшний англи хэл, математик болон коллежийн түвшний хичээлүүдийг сайн дүнтэй суралцсан нь хангалттай байдаг. Мэдээж их сургуульд шилжин суралцахын тулд коллежийн голч дүн, нийгмийн идэвх, зорилго тодорхойлсон эсээ зэрэг нь сайн байх хэрэгтэй байдаг бөгөөд мөн маш олон оюутнууд шилжин суралцахаар материалаа явуулж өрсөлддөг. 1-р курсээсээ ороход явагддаг процесстай яг адилхан гэсэн үг. Нэг үгээр хэлбэл, ерөнхий хичээлүүдээ коммунити коллежид үзээд яг мэргэжилийнхээ хичээлээ их сургуулидаа үзнэ гэсэн үг. Миний хувьд A-level ээ Хими, Биологи, Математик гэсэн хичээлүүдээр өгсөн нь маш их хэрэг болсон.

Юун түрүүнд нилээдгүй хувь их сургуулийн материалтай адилхан байдаг болохоор ирээд хичээлээ ойлгоход дөхөм, цаг хэмнэнэ мөн манай сургууль (ихэнх сургууль) A-level-д кредит тооцдог болохоор ирээд маш олон кредит ээ тооцуулан авсан. University of Minnesota, Twin cities буюу Миннесотагийн их сургууль нь Academic Ranking of World University (ARWU)-н 2016 оны жагсаалтаар 33-р байрт шалгарсан улсын сургууль юм. Тиймээс миний хувьд мэргэжилийн чиглэл болон сургууль тохирсон болохоор төрийн сургалтын сангийн зээлд хамрагдсан. Мөн сургуулиасаа Global excellence scholarship авсан. Хуулийнхаа дагуу оюутнууд 20хүртэлх цагийн ажил хийх эрхтэй, мөн төгсөөд нэг жилийн хугацаанд мэргэжилээрээ ажиллах эрхтэй байдаг болохоор хичээлийнхээ хажуугаар тохируулаад сургууль дотроо ажиллах бүрэн боломжтой байдаг.

Хураангуй:

- Боломж байвал коммунити коллежээр дамжвал зүгээр.
- A-level их хэрэг болдог. Манай сургуулийн сурагчдын хувьд энэ нь давуу тал учраас өгчихөд илүүдэхгүй.
- Америкад сурахын давуу талуудын нэг нь мэргэжлээ тэр даруйдаа сонгох хэрэггүй байдаг, 1 эсвэл 2 жил сурчихаад шийдэж болно.
- Ирээд ажил хийгээд төлбөрөө олно гэдэг бол маш хэцүү, яагаад гэвэл гол зорилго нь сурах байтал хэрвээ хажуугаар нь төлбөрөө олох хэмжээний ажил хийнэ гэвэл хичээл орхигддог.
- Англи хэлээ сайн суралцах.

Миний бичсэн зүйлийг уншсан та бүхэнд баярллаа, хэрвээ асуух асуулт болон нэмж тодруулах юм байвал molom002@umn.edu э-мэйл бичээрэй.

ХҮНДЭТГЭСЭН,

М.МАНДХАЙ (2013 ОНЫ ТӨГСӨГЧ)



Би анх 2014 оны 8 сард АНУ-ын Миннесота мужийн Inver Hills Community College-д элсэн орж одоогийн байдлаар University of Minnesota-д тэнцэн суралцаж байна. Америкийн их дээд сургууль, коллежид элсэн суралцах гэж байгаа дүү нартаа тус болох үүднээс өөрийн туршлагаасаа хуваалцъя. Мэдээж бүх хүүхдүүд Дэлхийн топ том сургуулиудад шууд элсэн орж суралцах хүсэлтэй байдаг байх. Гэхдээ энэ нь дундаж орлоготой айлын хүүхдэд маш том даваа байдаг. Топ сургуульд 4 жил суралцаж Баклаварын зэргээ авахад дунджаар \$180,000 шаардлагатай байдаг бөгөөд олон улсын оюутанд тэтгэлэг, тусламж авах боломж хомс байдаг. Ийм учираас би шууд их сургуульд оролгүйгээр Community College-д элсэн орсон юм. Community College нь Баклаварын доод зэрэг буюу Associates Degree олгодог 2 жилийн сургууль. Америкийн их сургуулиуд эхний 2 жилдээ ихэвчлэн ерөнхий мэдлэг олгодог хичээлүүдийг үздэг ба эдгээр хичээлүүдийг Community College-д ч мөн адил заадаг.

Community College-д сурснаараа их сургуульд төлөх байсан төлбөрийн 50-70%-г хэмнэж болно. Гэхдээ Community College-д судалсан кредитууд зөвхөн тухайн муж болон ойролцоох мужуудын сургуулиудад бүрэн шилждэг ба холдох тусам зарим хичээлүүдийг дахин авах шаардлага гардаг. Тиймээс өөрийн орох хүсэлтэй Дэлхийн топ их сургуультайгаа ойрхон байрлах Community College-д сурахыг зөвлөе. Community College-оо төгсөөд их сургуулийн 3-р курст элсэн ордог бөгөөд тэнцэх магадлал нь олон

улсын оюутнуудын 1-р курст тэнцэн орох магадлалаас их байдаг. Ингэснээрээ их сургуульд 4 жил суралцсантай ялгаагүй мөн л адилхан дипломтой төгснө.

ХҮНДЭТГЭСЭН,

Ц. ЛХАГВАДУЛАМ, Э. БАТМӨРӨН
(2013 ОНЫ ТӨГСГӨЧ)

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

ХҮНДЭТ СУРАГЧИД АА

Америк улсын коллежд өргөдөл явуулахын тулд TOEFL, SAT, SAT Subject Tests, ахлах сургуулийн дүн, өөрийгөө харуулсан эссээ болон тодорхой асуултанд хариулсан эссээ, хичээлээс гадуур хийсэн үйл ажиллагааны жагсаалт, багшын тодорхойлолт гэх зүйлсийг шаарддаг. Бүгдийг нь амжилттай бүрдүүлэх нь нэр хүндтэй сургуульд ороход туслахаас гадна бидэнд хэрэгтэй тэтгэлэгийг авахад тусалдаг юм. Америкийн коллежууд шалгалтад авах ёстой оноо гэж заадаггүй бөгөөд ерөнхийдөө нийт өрөгдөл явуулсан сурагчдыг хооронд өрсөлдүүлчдэг юм. Өөрөөр хэлвэл хангалттай оноо хэд вэ гэдэгийг мэдэх шаардлаггүй, харин хамаг чадахаараа шалгалтуудыг нь өгөх хэрэгтэй. Миний хувьд SAT шалгалтыг 2060, TOEFL IBT шалгалтыг 110 оноотой өгсөн. Эдгээр шалгалтанд бэлдэхдээ өөрийгөө хуурахгүй тогтмол бэлдэж чадвал тодорхой хугацаанд хүссэн оноогоо авч чадна.

Би Америк улсын Michigan мужын Albion гэх жижиг либэрал артс сургуульд Psychology, Economics double major болон French minor суралцаж байгаа бөгөөд өөрийн сургуульдаа сэтгэл маш өндөр байна. Учир нь либэрал артс сургууль нь сурагчдыгаа амжилтанд хүргэх, сэтгэл хангалуун байлгах талдээр хором бүрд ажиллаж байгааг мэдэрч байна. Ажил олж өгөхөөс авахуулаад мэрэгжлийн сэтгэл судлаач хүн өдөр тутамд туслахад. Хөлөө гэмтээхэд сургуулиас байгаа газар нь ирж аваад эмнэлэг хүргэж өгөөд буцаад байрлуу маань хүргээд өгдөг юм байна, мөн зардал нь сургуулийн даатгалаас гарах гээд маш олон гайхмаар зүйлсийг жижиг сургуульд харж

байна. Хичээлийн тал дээр гэвэл, багш нар маань яг л найз шиг, сурагчидаа хичээлийг нь ойлгуулахын тулд бүх л зүйлсийг хийж байгаа нь өдөр тутамд харагдаж байна. Үнэгүй пиззатай уулзалт гээл.

Жижиг сургуулийн сул тал гэвэл ихэнх хүмүүс сургуулийг маань мэддэггүй. Ялангуяа, Монголд коллеж гэхээр их сургуульд биш бэлтгэлд сууж байгаа мэт ойлгодог. Үнэндээ бол коллэж нь баклавар зэрэг олгодог байгуулага юм. За тэгээд Америк улсад асуухгүй бол байхгүй гэдэг зүйлийг улам ихээр сурч байна. Зөвхөн асуух ч биш, оролдож хичээхгүй бол хэн ч миний өмнөөс хичээхгүй гэдэг ойлголт юм. Маш энгийн ч гэсэн, олон хүмүүс би чадахгүй дээ, угаасаа боломжгүй гээд л яваад байдаг шүү дээ. Эцэст нь Шинэ Эрин сургуульдаа дэлхийд гологдохгүй боловсрол мэдлэг ологсонд маш их талархаж байна. Мөн шалгалтанд бэлдэх ба Америк их сургуулийн талаар Америк сурагчдад ч байдаггүй мэдлэг олоход тусалсан Томүжин ТББ хамт олонд талархаж байна.

ХҮНДЭТГЭСЭН,
Б. СУБЭЭДЭЙ (2014 ОНЫ ТӨГСӨГЧ)
НДЭТ СУРАГЧИД АА,



Хишигбаярын Энхзул миний бие нь 2013 онд “Шинэ-Эрин” олон улсын лаборатори сургуулийн 11-р ангийг амжилттай дүүргэж, тухайн үед олон улсын AS, A түвшнийг үргэлжлүүлэн судлах сонирхолтой байсан тул 12-р ангид дэвшин суралцаж 2014 онд амжилттай төгссөн. Тухайн жилийн 9-р сард БНХАУ-ын “Бээжин дэх Хятадын газрын тосны их сургууль”-д элсэн орж өнөөдөр 3 дахь жилдээ амжилттай суралцаж байна. Манай сургууль нь улсдаа 15-р байранд жагсдаг, газрын тосны чиглэлээр БНХАУ-д 1-р байранд жагсдаг сургууль юм.

Миний хувьд Ерөнхий Боловролын 1-9-р ангийг Улсын тэргүүний лаборатори 1-р сургуульд суралцаж, суралцах хугацаандаа “Шинэ-Эрин” сургуулийн элсэлтийн шалгалтанд тэнцэн 2010 оны 11-р сараас эхлэн “Шинэ-Эрин” сургуульд суралцаж эхэлсэн бөгөөд тус сургуулийн анхны төгсөгчдийн нэг юм. “Шинэ-Эрин” сургуульд байх хугацаандаа Cambridge-ийн IGCSE түвшинд англи хэл, математик, бизнес судлал, компьютер судлал, физикийн хичээлүүдийг сонгон судалж, үргэлжлүүлэн AS, A түвшинд физик, математик, бизнес судлал хичээлүүдийг гүнзгийрүүлэн судалсан. Түүнчлэн төгсөх жилээ гадаадын их дээд сургуулиудыг идэвхтэй хайн, АНУ-ын их дээд сургуулиудын шаардлагыг хангах TOEFL, SAT шалгалтуудыг мөн амжилттай өгсөн.

Одоогийн миний сурч байгаа “Бээжин дэх Хятадын газрын тосны их сургууль”-д гадаад оюутан нийт 6 төрлийн мэргэжлийг сонгон суралцдаг. Үүнд: Газрын тосны ерөнхий инженер, Геологийн инженер, Хими, технологийн инженер, Тос болон хийн хадгалалт тээвэрлэлтийн инженер, Механик дизайн, үйлдвэрлэл болон автоматжуулалтын инженер, Олон улсын эдийн засаг, худалдаа гэсэн мэргэжлүүд

багтана. Сургуулиас оюутнуудад олгодог нэг давуу тал нь тухайн оюутан хэрэв хүсээд, голч оноо нь дээгүүр бол хоёр дахь мэргэжлийг сонгон судлах боломжтой. Миний хувьд ЕБС-д байх хугацаандаа компьютер судлал, физик, математик, бизнес судлал хичээлүүдийг гүнзгийрүүлэн судалж байсан тул эхний мэргэжлээ “Механик дизайн, үйлдвэрлэл болон автоматжуулалтын инженер”-ийг сонгож, 2 дахь мэргэжлээрээ “Олон улсын эдийн засаг, худалдаа”-г сонгосон.

Жил бүр Монголын ашигт малтмал, газрын тосны газар (хуучнаар газрын тосны газар)-аас оюутан залуусын дунд газрын тосны чиглэлээр ОХУ-ын “Губкиний нэрэмжит нефть, газрын тосны их сургууль”, “Бээжин дэх Хятадын газрын тосны их сургууль”, мөн БНХАУ-ын “Дачиний газрын тосны их сургууль”-д элсэн суралцах тэтгэлэгт сонгон шалгаруулалт зарладаг бөгөөд шалгалтанд математик, англи хэлний мэдлэгийг шалгадаг. Тус шалгалтанд тэнцсэн эхний 15 оюутан дээрх их сургуулиудын нэгийг сонгон суралцах тэтгэлэгийг олж авдаг бөгөөд миний хувьд ЕБ-н “Шинэ-Эрин” лаборатори сургуульд байх хугацаандаа тус 2 хичээлийг гүнзгийрүүлэн судалсан учраас шалгалтад тэргүүн байранд орж “Бээжин дэх Хятадын газрын тосны их сургууль”-д элсэн суралцах 100%-ийн тэтгэлэг, мөн дотуур байр, сар бүрийн амьжиргааны зардлын мөнгө авах эрхийг олж авсан. Суралцах болон оршин суух визний хувьд хэдийгээр Монгол улсын иргэн БНХАУ-руу 30 хоногийн дотор визгүй зорчдог боловч, сургалтын виз учраас эхлээд Монгол дахь БНХАУ-ын элчингээс 1 сарын визийг аван, БНХАУ-д ирснээс хойш нэг сарын дотор дахин урт хугацаанд оршин суух визийг авах ёстой.

Шалгалтад тэнцсэний дараа зайлшгүй хийх ёстой зүйл бол тус сургуульд нэг

жилийн хэлний бэлтгэл курсэд суух ба жилийн эцэст HSK4 зэргийн шалгалт өгч тэнцэх хэрэгтэй. Түүгээр ч зогсохгүй хэлний бэлтгэлд хичээлийн улиралын дунд болон төгсгөлд нийт 2 шалгалт авч суралцагчдыг жагсаадаг ба үүнд 60%-с доош авах буюу унасан тохиолдолд эсвэл HSK4 шалгалтандаа тэнцээгүй тохиолдолд их сургуульдаа суралцах эрхгүй болж дахин хэлний бэлтгэл курсэд суух хэрэгтэй болдог. Миний бие “Шинэ-Эрин” сургуульд багш, ажилчдын ачаар өөрийн сурах арга барил, ачаалал даах чадварыг сайжруулж чадсан тул дээрх шалгалтуудыг амжилттай өгч сургуульдаа нэгдүгээр байрт жагсаж их сургуульдаа суралцах боломжийг олж авсан.

Оюутны амьдрал гэдэг бол ЕБС-ын амьдралаас тэс өөр бөгөөд ялангуяа гадаад оронд сурах бол тэс өөр орчин, нийгэмд орж ирж байна гэсэн үг юм. ЕБС-д чи ээж, аав, багш, сурган хүмүүжүүлэгчидийнхээ дэмжлэгээр сурч боловсорч, амьдарч байсан бол их сургуульд бүх зүйл чиний өөрийн гарт байна гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр хүний амьдралын замыг шийдэх хамгийн том даваан дээр ирлээ гэж ойлгож болно. Жишээлбэл, ЕБС-д хичээлээ хийхгүй бол эцэг, эх, багш нар хажуугаас хэлээд, тусалж дэмжээд зөв зам руу орж болдог байхад их сургуульд хэн ч чамд хэлэхгүй бөгөөд өөрөө л түүнийг эргэцүүлэн муу зүйлээс хол байхгүй бол нэгэнт оройтсон байдаг. Үүнээс гадна гадаад оронд сурч боловсорч байхад чамтай хамт чиний эх орны нэр мөн алхаж байдаг. Гадаад хүмүүс анх харахдаа чиний нэрээр биш Монгол гэж бодож ярьдаг. Жишээ нь чи онц сурч, бусдыг манлайлахад энэ “Монголчууд мундаг, онц сурдаг” гэж ярихаас, энэ Батаа эсвэл Дулмаа гэж ховорхон ярьдаг. Тийм учраас эх орныхоо нэрийг бодон биеэ мөн зөв авч явах хэрэгтэй.

Манай сургуулийн хувьд хотын төвөөс зайдуу оршдог, Бээжин хотын цэвэр агаарын бүсэд байдаг тул агаарын бохирдол харьцангуй бага, хүн амын нягтшил ч мөн сийрэг байдаг. Тэтгэлэгт сургалтын зардал, байрны мөнгө мөн

сар бүрийн хоолны мөнгө багтсан байдаг тул ар гэрээсээ бүрэн тусдаа гарсан гэхэд болно. Хятадад сурсны давуу тал нь хамгийн түрүүнд хятад хэл сурах юм. Хятад хэл нь дэлхийн хамгийн хэцүү хэлний нэг бөгөөд Хятадад сурснаар орчинд нь төгс эзэмших боломжийг олж авч байна гэсэн үг юм. Түүнчлэн хятад хэл сурсанаар дэлхийн 1 тэрбум 300 сая хүнтэй чөлөөтэй харилцаж чаддаг болох бөгөөд мэдээллийн тенологийн эрин үед бусдаас нэг дахин их мэдээллийг олж авах боломжтой боллоо гэсэн үг. Мөн одоогоор Монголд Хятадын олон компани ажилладаг үчраас их сургуулиа төгсөөд очиход Хятад хэлтэй тул ажил олоход ч мөн арай хялбар болно. Дараагийн нэг давуу тал нь Хятад улсын үсрэнгүй хөгжилийг өөрийн биеэр мэдрэх боломжтой болох юм. Үүгээр ч зогсохгүй Хятад улсын барааны үнэ Монгол болон бусад улсынхаас маш хямд байдаг тул олон оюутнууд Хятад Монголын хооронд бэлэн бараа зөөн зардаг бөгөөд энэ нь нэг талаар өөртөө бизнесийн арвин туршлага суулгаж байгаа явдал бөгөөд нөгөөтэйгүүр үүнээс ирээдүйнхээ бизнесийн санааг ч олж болох юм. Хүн ам ихсэх хэмжээгээр тухайн улсад гарах гэмт хэрэг, хууль зөрчигчдийн тоо ч мөн ихсэх хандлагатай байдаг. Үүнтэй холбоотойгоор Хятад улсын гэмт хэргийн тоо ч мөн харьцангуй их байдаг. Гэхдээ суралцагч та өөрөө буруу зүйлээс, муу зуршлаас өөрийгөө хол байлгах юм бол муу зүйл ч гэсэн холуур өнгөрнө.

Мэргэжил сонгох, сургуулиа сонгох гэдэг бол өөрийн чинь ирээдүйг тодорхойлох нэг том хэмжүүр учраас эцэг эхийн болон багш сурган хүмүүжүүлэгчдийн санал бодлыг үндэслэн, сурч болох сургуулиудыг сайн судлан сонгох нь зөв зүйтэй юм. Хамгийн гол нь мэргэжил гэдэг бол чиний насаараа өдөр болгон хийх зүйл учираас өөрийн сонирхлыг ч мөн харгалзах нь зүйтэй. Ингээд төгсөгч танд амжилт хүсье!

ХҮНДЭТГЭСЭН,

Х. ЭНХЗУЛ (2013 ОНЫ ТӨГСӨГЧ)



ХҮНДЭТ СУРАГЧИД АА

А нударь, Энхцацралт бид хоёр жилийн чөлөө аван өөрсдийн төгссөн Шинэ Эрин сургуульдаа ажилаж байгаа билээ. Бид хоёр 2016 онд сургуулиа төгссөн бөгөөд Сурагчдад Зөвлөх багшаар ажиллаж байгаа юм. Жилийн чөлөө авсан туршлагаасаа хуваалцах гэсэн юм.

Г ар year буюу жил өнжих/жилийн чөлөө гэдэг нь ахлах сургуулиа төгсчхөөд нэг жил их сургуульд орохоосоо өмнө чөлөө авахыг хэлдэг юм. Хэрэв жилийн чөлөө авахыг хүсвэл маш нарийн бодож шийдэх хэрэгтэй. Сурагчдад жилийн чөлөө авах олон шалтгаан байдаг. Эдгээр шалтгаануудад туршлага хуримтлуулах, ертөнцийг үзэх үзлээ томсгох, өөрийгөө сорих, мөнгө хураах болон их дээд сургуулийн өргөдөл явуулах үйл явцад бэлдэх ордог. Энэ жилийн хугацаандаа сурагчид аялах, ажиллах, суралцах, их сургуулийн өргөдөл явуулах үйл явцад бэлдэх, сайн дурын ажил хийх гэх мэтчилэн ашигладаг.

Тэгвэл жилийн чөлөө авахын эерэг ач холбогдол нь:

Жилийн чөлөө авсанаар сурагчид туршлага хуримтлуулж, амьдралын ухаанд суралцдаг. Ингэснээр гадаадын их дээд сургуульд суралцахад гэнэн хуумгай алдаа гаргалгүй, өөрийгөө харийн оронд авч явах чадвартай болдог.

Хүссэн их дээд сургуульдаа жилийн турш бэлдэж шаардлагатай шалгалтын оноо бүрдүүлэх материалаа бэлдэх боломж гардаг. Тэгэхээр тэр их дээд сургуульдаа орох магадлалаа өсгөдөг.

Монгол сурагчид залуухан буюу 16, 17 настайдаа төгсөх нь олонтой. Харин гадаадын сурагчид их дээд сургуулиудад

хамгийн залуудаа 18 эсвэл 19 настайдаа ордог байна. Тиймээс ч наснаасаа болж гарах асуудал тулгардаггүйгээрээ бас ашигтай байдаг.

Сурагчид өөрийгөө нээж таньж мэддэг болно. Энэ нь ямар мэргэжилтэй болох, ирээдүйд юу хийх гэх мэтчилэн асуултнуудад хариу өгөх шийдвэр гаргахад хувь нэмэр болдог.

Жилийн чөлөө авах гэдэг нь маш ач холбогдолтой шийдвэр бөгөөд хөнгөхөн хандаж болохгүй. Тиймээс нухацтай тунгаан бодсоны эцэст шийдэх нь чухал.

Харин сөрөг ач холбогдол нь:

Нэг жилийн хугацаа алдана. Сургуулиа төгсөөд нэг жил өнжихөөр их сургуульд явтлаа нэг жилийн хугацааг алдана гэсэн үг юм. Тэгэхээр ингэж цаг алдаж байхаар их сургуульд орсон нь дээр гэж бодож байвал жилийн чөлөө авах хэрэггүй. Цуг төгссөн найз нөхөд чинь аль хэдийн сургуульдаа орсон байхад чи ороогүй байх нь нэг талаараа дутагдалтай тал юм.

Хамаатнууд болон тандаг хүмүүсийн байнгын асуултанд хариулахад хэцүү. Олон уулздаггүй юм аа гэхэд Цагаан сараар ч юм уу хааяа нэг таарах үе бий. Тэр үед эдгээр хүмүүс чиний ямар сургуульд орсныг асуух болно. Харин жил өнжиж байгаа гэдгээ хэлэх үед их гайхдаг. Шалгалтандаа унасан юм уу, бие чинь өвдөө юу гэх мэт олон

зүйл асууна. Энэ бүрт чи нэгд нэгэнгүй хариулахад төвөгтэй, заримдаа ичмээр ч юм шиг байдаг. Учир нь хичнээн сайн тайлбарласан ч, тэдгээр хүмүүс чиний талаар тодорхой хэмжээний таагуу зүйлийг л боддог. Ялангуяа эцэг эх чинь чиний өмнөөс их "улайдаг". Тэд чиний шийдвэрийг хүндэтгэж байгаа ч, бусад хүмүүсийн бодол тэдэнд ч гэсэн хамаатай.

Жил өнжиж өргөдлөө явуулаад дахиад тэнцэхгүй бол их олон зүйлийг алдана.

Жилийн чөлөө авах нь нэг талаараа их эрсдэлтэй. Нэг жилээ золиослон байж өргөдлөө бэлдээд гадаадын их сургуулиудад явуулсан чинь, тэнцэхгүй бол чамд дотоодын их сургуульдаа орно гэсэн ганцхан л сонголт үлдэж байгаа юм. Гэхдээ үүнийг дагаад нэг жилийн хугацаа алдсан байдал, эцэг эхийн сэтгэлээр унасан царай, хамаатнуудын зэмлэл, тэгээд бас өөртөө гомдожшантарсан сэтгэлзүй ирнэ. Тиймээс эрсдэл гаргахдаа эргэлзэж байвал жилийн чөлөө авах нь тун эрсдэлтэй. Гэхдээ нөгөө талаар өөртөө итгэлтэй, чадна бүтээнэ гэсэн сэтгэлзүйтэй байгаа бол Жилийн Чөлөө авснаараа чи амьдралынхаа том хэсгийг өөрчлөх боломжийг олж авах болно.

ХҮНДЭТГСЭН,
Э.ЭНХЦАЦРАЛТ
Ш. АНУДАРЬ
(2016 ОНЫ ТӨГСӨГЧИД)

